



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/237

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга (Өвөрхангай, Арвайхээр сум, 4 дүгээр цэцэрлэг) ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Ганболд -Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Т.Гантулга -Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Н.Чимэддорж-Ойдов -Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

Т.Нарангарав -Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч

А.Оюунчимэг -Орон нутгийн сургалт, судалгааны хөгжлийн агентлаг

ТББ-ын удирдах зөвлөлийн дарга (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Н.Ганболд)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Т.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100525